

“БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК” ХК-ИЙН ХҮНИЙ НӨӨЦИЙН ХӨГЖЛИЙН СТРАТЕГИ

Хүний нөөцийн хөгжлийн эрхэм зорилго

“Багануур үйлдвэрлэл, технологийн парк” ХК нь олон улсын жишигт нийцсэн эко үйлдвэрлэлийн парк болох алсын хараа, эрчимтэй хөгжлийн шинэчлэл нь үйлдвэрлэл технологийн парк байна хэмээх эрхэм зорилго, байгальд ээлтэй, өндөр технологи бүхий аж үйлдвэрийн цогцолбор байгуулж, импортыг орлох, экспортын баримжаатай бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг хөгжүүлж, ажлын байруудыг шинээр нэмэгдүүлэх, нийслэлийн хүн амын хэт төвлөрлийг бууруулахад тодорхой нөлөөллийг бий болгож, бүс нутгийн нийгэм эдийн засгийн хөгжлийг шинэ шатанд дэвшүүлэх үндсэн зорилтуудыг хэрэгжүүлэн ажиллах үндсэн чиг үүрэгтэй.

Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр болон Нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгагдсан хүний нөөцийн хөгжлийн бодлогыг хэрэгжүүлнэ.

Компанийн дүрмээр хүлээсэн дээрх чиг үүрэг, зорилго, зорилтуудыг хэрэгжүүлэх, төрийн алба, улс орны нийгэм эдийн засгийн хөгжлийн чиг хандлагад нийцсэн өөрчлөлт шинэчлэлтэд зохицож чадах үнэт зүйлс, мэдлэг чадвар бүхий хүний нөөцийг бүрдүүлэх, төлөвшүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааг зохион байгуулах, чиг үүргээр хангахад чиглэсэн арга хэмжээний мэдээллээр хангахад тус баримт бичгийн зорилго оршино.

Хүний нөөцийн хөгжлийн стратеги

Компанийн хүний нөөцийн удирдлагын хүрээнд дэвшүүлж буй стратегийн зорилтууд:

Нэг.Хүний нөөцийн цогц механизмыг төлөвшүүлэх

- Хүний нөөцийн хөтөлбөр, төлөвлөгөө, төсөл боловсруулан, батлуулж хэрэгжүүлэх, хэрэгжилтийг зохион байгуулалт, удирдлагаар хангах
- Хүний нөөцийн асуудлаар гадаад хамтын ажиллагааг хөгжүүлэх арга хэмжээ зохион байгуулах

Хоёр.Компанийн эрхэм зорилгыг биелүүлэх, зорилт, чиг үүргийг хэрэгжүүлэхэд чиглэсэн гүйцэтгэлийн удирдлагын тогтолцоог төлөвшүүлэх, удирдах албан тушаалтнуудын манлайллын чадавхыг хөгжүүлэх

- Газар, нэгжийн удирдлага болон бусад албан тушаалтнуудад стратеги төлөвлөлт, гүйцэтгэлийн менежмент, бодлогын дүн шинжилгээ, мониторинг үнэлгээ хийх зэрэг асуудлаар мэдлэг чадвар бий болгох арга хэмжээ авах, хэрэгжүүлэх болон төлөвшүүлэх ажлыг зохион байгуулах
- Салбарынхаа хэмжээнд стратегийн түвшинд бодож сэтгэх, зорилгодоо хүрэх арга замыг зөв тодорхойлж чаддаг байх
- Байгууллагын дотоод болон гадаад орчны хүрээнд үр бүтээлтэй ажлын харилцааг буй болгох, бусадтай нөлөө бүхий ажлын харилцаа тогтоох, бусдыг уриалан дуудаж чаддаг байх
- Өөрийн биеэр үлгэрлэн өөрийгөө дайчлан, шударгаар ажиллах, бусдад урам хайрлаж, зоригжуулж чаддаг байх
- Бусдаар хүлээн зөвшөөрүүлж, үр дүнд хүрэх зэрэг гол чадварыг эзэмшсэн байх

Гурав. Албан хаагчдыг хөгжүүлэх, карьер өсгөх стратеги хэрэгжүүлэх

- Төрийн албан хаагчдыг шилж сонгох механизмыг боловсронгуй болгох, мэргэшсэн, дадлага туршлагатай албан хаагчдаар баг бүрдүүлэх
- Тухайн ажилтныг хөгжүүлэх хэрэгцээг байгууллагын тэргүүлэх чиглэл, өөрчлөлтөд уялдуулан тодорхойлох
- Албан хаагчдыг өсгөж хөгжүүлэх сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө гаргаж хэрэгжүүлэх, сургалтад хамруулах, үйл ажиллагаанд сургалтын мэдээ мэдээлэл, үр дүнг тусгаж ажиллах
- Олон улсын болон дотоодын шилдэг хүний нөөцийн менежменттэй компаниудын дэвшилтэт туршлагаас судалж, суралцан хүний нөөц бэлтгэх механизмтай болох

Дөрөв. Албан хаагчдыг ажиллах нөхцөл, нийгмийн баталгаагаар хангах механизм төлөвшсөн байх

- Ажилтнуудын нийгмийн баталгааг хангах асуудлыг Төрийн албаны тухай хууль болон бусад хууль тогтоомжийн дагуу бүрэн хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгө, нөөцийг Компанийн төсөвт жил бүр тусган хэрэгжүүлж байх
- Цалин хөлс, урамшууллын системийг өрсөлдөх чадвартай болгох
- Ажлын байрны тохижилт, шинэчлэлтийг орчин үеийн оффисын стандартын жишигт нийцүүлэн тохижуулах ажлыг үе шаттай хэрэгжүүлэх
- “Багануур үйлдвэрлэл, технологийн парк” ХК-ийн “Албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр”-т тусгагдсан арга хэмжээг Компанийн төсвийн хэмнэлтийн санхүүжилтээр, Компанийн хөдөлмөрийн дотоод журамтай уялдуулан хэрэгжүүлнэ.

Тав. Мэдээллийн ил тод байдлын тухай хуультай уялдуулан Хүний нөөцийн ил тод байдлыг хангаж ажиллах

- Сул орон тооны зарыг цахим хуудаст байршуулах, олон нийтийн мэдээллийн хэрэгслээр зарлах
- Албан хаагчийн ёс зүйн дүрмийг цахим хуудаст байршуулах, тухай бүр шинэчлэх
- Хүний нөөцийн стратеги хэрэгжилтийг хянах, үнэлэх журмыг цахим хуудаст байршуулах, тухай бүр шинэчлэх
- Үйл ажиллагааг үнэн зөв, шударга болгох чиглэлээр хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар цахим хуудсандаа мэдээлсэн байх

Дээр дурьдсан арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхэд шаардлагатай төсвийг жил бүр Компани хариуцаж санхүүжүүлнэ.

“БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК” ХК-ИЙН ХҮНИЙ НӨӨЦИЙН ХӨГЖЛИЙН СТРАТЕГИ ХЭРЭГЖИЛТ ХЯНАХ, ҮНЭЛЭХ

Хүний нөөцийн хөгжлийн стратеги хэрэгжилтийг хянаж, үнэлэхдээ “Багануур үйлдвэрлэл, технологийн парк” ХК-ийн Хүний нөөцийн хөгжлийн стратеги хэрэгжилт хянах, үнэлэх тухай Хавсралт маягтыг ашиглана.

Үнэлгээг Гүйцэтгэх захирал, Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Бодлогын хэрэгжилт, төлөвлөлтийн газрын дарга, Хүний нөөц хариуцсан мэргэжилтнээс бүрдсэн Үнэлгээний баг хариуцаж хийнэ.

Хүний нөөцийн хөгжлийн стратеги хэрэгжилтэд ёс зүйн үнэт зүйлсийг хэвшүүлэх зарчмыг баримталж ажиллана.

Тус Компанийн нийт албан хаагчид төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг сахин биелүүлдэг, итгэлцэл-хүндэтгэл-ажил хэрэгч байдал гэсэн зарчмаар ажилладаг байх нь Компанийн үйл ажиллагаа, соёлын чухал үндэс гэж үзнэ. Компанийн албан хаагчид нь Монгол Улсын Төрийн албаны тухай хууль, Авлигалын эсрэг хууль болон Засгийн газрын 1999 оны 58 дугаар тогтоолоор баталсан “Төрийн захиргааны албан тушаалтны ёс зүйн дүрэм”-д заасан ёс зүйн хэм хэмжээг чанд сахиж ажиллахын хамт дараах үндсэн хэм хэмжээг баримталж ажиллана. Үүнд:

- Үндсэн хууль, хууль тогтоомжийг хувийн ашиг сонирхлоос дээгүүр тавьж сахин биелүүлнэ.
- Төрийн албаны эрх, үүргийг хэрэгжүүлэх ажилдаа хувийн санхүүгийн сонирхолтой байж болохгүй.
- Өөрт мэдэгдсэн төрийн болон төрийн бус байгууллага, хувь хүний нууцтай холбоотой мэдээллийг задруулах, хувийн зорилгоор ашиглах ёсгүй.
- Ажлын цагаар, ажлын байранд согтуу байх болон согтууруулах ундааны зүйл хэрэглэхийг хориглоно.
- Өөрийн албаны эрх, үүрэгт хамаарахгүй асуудлаар шийдвэр гаргах болон үүрэг хүлээх, амлалт авахыг хориглоно.
- Ажилдаа чин сэтгэлээсээ хандаж, албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргээ хариуцлагатай, үр бүтээлтэй биелүүлнэ.

Эдгээр ёс зүйн хэм хэмжээг мөрдөж ажиллах явдлыг ажилтны хөдөлмөрийн гэрээний хэрэгжилт, Ажилтны ажил үүргийн гүйцэтгэлийг жил бүр дүгнэж ажиллана. Түүнчлэн төрийн албан хаагчийн ёс зүй, харилцааны сэтгэл зүй, удирдлагын сэтгэл зүйн чиглэлээр ажилтнуудыг сургалт, лекц, хөтөлбөрт хамруулах, сургалт зохион байгуулах ажлыг үе шаттай зохион байгуулна. Ингэснээр ажилтнуудын дунд ёс зүйн үнэт зүйлсийн үнэлэмж дээшилж, хамт олны дунд найрсаг, бие биеэ хүндэтгэсэн соёл төлөвшиж, төдий чинээгээр байгууллагын үйл ажиллагааны чадавх сайжирна.

**“БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК” ХК-ИЙН ХҮНИЙ НӨӨЦИЙН
ХӨГЖЛИЙН СТРАТЕГИ ХЭРЭГЖИЛТИЙГ ХЯНАЖ, ҮНЭЛЭХ МАЯГТ**

2025 оны 06 дугаар сарын 26

Багануур дүүрэг

Д/д	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Гүйцэтгэлийн мэдээ, түвшин	Хугацаандаа хэрэгжүүлсэн байдал/Огноо	Оноо
1.Хүний нөөцийн цогц механизмыг төлөвшүүлэх				
1.1	Хүний нөөцийн хөтөлбөр, төлөвлөгөө, төсөл боловсруулан, батлуулж хэрэгжүүлэх, хэрэгжилтийг зохион байгуулалт, удирдлагаар хангах			
1.2	Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгаа хангах төлөвлөгөө, төлөвлөгөөний хэрэгжилт			
2.Компанийн эрхэм зорилгыг биелүүлэх, зорилт, чиг үүргийг хэрэгжүүлэхэд чиглэсэн гүйцэтгэлийн удирдлагын тогтолцоог төлөвшүүлэх, удирдах албан тушаалтнуудын манлайллын чадавхыг хөгжүүлэх				
2.1.	Газар, нэгжийн удирдлага болон бусад албан тушаалтнуудад стратеги төлөвлөлт, гүйцэтгэлийн менежмент, бодлогын дүн шинжилгээ, мониторинг үнэлгээ хийх зэрэг асуудлаар мэдлэг чадвар бий болгох арга хэмжээ авах, хэрэгжүүлэх болон төлөвшүүлэх ажлыг зохион байгуулах			
2.2.	Салбарынхаа хэмжээнд стратегийн түвшинд бодож сэтгэх, зорилгодоо хүрэх арга замыг зөв тодорхойлж чаддаг байх			
2.3.	Байгууллагын дотоод болон гадаад орчны хүрээнд үр бүтээлтэй ажлын харилцааг буй болгох, бусадтай нөлөө бүхий ажлын харилцаа тогтоох, бусдыг уриалан дуудаж чаддаг байх			
3.Албан хаагчдыг хөгжүүлэх, карьер өсгөх стратеги хэрэгжүүлэх				
3.1.	Албан хаагчдыг сонгон шалгаруулах механизмыг боловсронгуй болгох, мэргэшсэн, дадлага туршлагатай албан хаагчдаар баг бүрдүүлэх			
3.2.	Ажилтнууд, ажиллагсдынхаа дадлага чадвар, хүсэл сонирхол, ажлын хэрэгцээг тооцсон судалгаа, мэдээлэлтэй байх			
3.3.	Тухайн ажилтныг хөгжүүлэх хэрэгцээг байгууллагын тэргүүлэх чиглэл, өөрчлөлтөд уялдуулан тодорхойлох			
3.4.	Албан хаагчдыг өсгөж хөгжүүлэх сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө гаргаж хэрэгжүүлэх, сургалтад хамруулах, үйл ажиллагаанд сургалтын мэдээ мэдээлэл, үр дүнг тусгаж ажиллах			
3.5.	Байгууллагын үйл ажиллагааны талаар албан хаагчдаас сэтгэл ханамжийн судалгаа авах			
3.6.	Хүний нөөцийн асуудлаар гадаад хамтын ажиллагааг хөгжүүлэх арга хэмжээ зохион байгуулах			

4.Албан хаагчдыг ажиллах нөхцөл, нийгмийн баталгаагаар хангах механизм төлөвшсөн байх				
4.1.	Ажилтнуудын нийгмийн баталгааг хангах асуудлыг Төрийн албаны тухай хууль болон бусад хууль тогтоомжийн дагуу бүрэн хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгө, нөөцийг Компанийн төсөвт жил бүр тусган хэрэгжүүлж байх			
4.2.	Цалин хөлс, урамшууллын системийг өрсөлдөх чадвартай болгох			
4.3.	Ажлын байрны тохижилт, шинэчлэлтийг орчин үеийн оффисын стандартын жишигт нийцүүлэн тохижуулах ажлыг үе шаттай хэрэгжүүлэх			
4.4.	"Багануур үйлдвэрлэл, технологийн парк" ХК-ийн "Албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр"-т тусгагдсан арга хэмжээг Компанийн төсвийн хэмнэлтийн санхүүжилтээр, Компанийн хөдөлмөрийн дотоод журамтай уялдуулан хэрэгжүүлнэ.			
5.Хүний нөөцийн ил тод байдал				
5.1.	Сул орон тооны зарыг цахим хуудаст байршуулах, олон нийтийн мэдээллийн хэрэгслээр зарлах			
5.2.	Албан хаагчийн ёс зүйн дүрмийг цахим хуудаст байршуулах, тухай бүр шинэчлэх			
5.3.	Хүний нөөцийн стратеги хэрэгжилтийг хянах, үнэлэх журмыг цахим хуудаст байршуулах, тухай бүр шинэчлэх			
5.4.	Үйл ажиллагааг үнэн зөв, шударга болгох чиглэлээр хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар цахим хуудсандаа мэдээлсэн байх			

ТӨСӨЛ БОЛОВСРУУЛСАН:
 ГАДААД ХАРИЛЦАА, ХҮНИЙ
 НӨӨЦИЙН МЭРГЭЖИЛТЭН *М. Мөнхдулам* М.МӨНХДУЛАМ